# Шинжээчийн үнэлгээний тайлан

Байгууллагын нэр: ИХ ЗАСАГ, ЧИНГИС СООСЭ СУРГУУЛЬ

Хөтөлбөрийн нэр: ОЛОН УЛСЫН ХАРИЛЦАА

Индекс: 031202

Шинжээчийн баг:

Ахлагч: Ж. Баттогтох ( МУИС-ийн ОУХНУС-ийн ОУХ-ны тэнхмийн профессор, доктор)

Гишүүд: С.Сэрчмаа ( Олон улсын Улаанбаатарын Их сургуулийн англи хэлний тэнхмийн багш, доктор)

И.Энхболд (Шинжлэх Ухааны Академийн Олон улс судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор)

2023 он

**Агуулга**

**Товчилсон үгийн тайлбар**

**I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт**

**II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга**

**III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт**

Шалгуур1: Хөтөлбөрийн төлөвлөлт

Шалгуур 2: Сургалтын үйл ажиллагаа

Шалгуур 3: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Шалгуур 4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Шалгуур 5: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Шалгуур 6: Багшийн үйл ажиллагаа

Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажилт

**IV. Уулзалтад оролцогчдын нэрс**

I. Багш нарын нэрс

II. Оюутнуудын нэрс

III. Ажил олгогчдын нэрс

IV. Төгсөгчдийн нэрс

**V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал**

**YI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр**

**YII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр**

**Товчилсон үгийн тайлбар**

-

## I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

| | | |
|---|---|---|
| **Сургуулийн нэр /Монгол, Англи/** | ИЗОУИС, Чингис СООСЭ сургууль | |
| **Сургалтын хөтөлбөрийн нэр /Монгол, Англи/** | Олон Улсын харилцаа , бакалаврын хөтөлбөр | |
| **Индекс** | 031202 | |
| **Шинжээчид** | Ахлагч: 1. Ж. Баттогтох (МУИС-ийн ОУХНУС-ийн ОУХ-ны тэнхмийн профессор, доктор)<br>Гишүүд: 2. С.Сэрчмаа ( Олон Улсын Улаанбаатарын Их сургуулийн англи хэлний тэнхмийн багш, доктор)<br>3. И.Энхболд (Шинжлэх Ухааны Академийн Олон улс судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор) | |
| **БМИҮЗ-ийн ажлын албаны мэргэжилтэн** | Магадлан итгэмжлэл хариуцсан шинжээч Б.Оюунцэцэг | |
| **Төлөвлөгөө** | 2023.05.16 | Мэргэжилтэн шинжээчдэд ӨҮТ-г хүлээлгэн өгөх |
| | 2023.05. 19 | Шинжээчийн урьдчилсан үнэлгээний тайланг мэргэжилтэнд өгөх |
| | 2023.05.23 | Сургуулийн бэлэн байдлыг нягтлах |
| | 2023.05.24,25 | Шинжээчид сургууль дээр ажиллах |
| | 2023.06.05 | Шинжээчиийн баг зохицуулагчид шинжээчийн тайланг илгээх |
| | | Магадлан итгэмжлэлд орж буй сургуульд шинжээчийн тайланг илгээх |
| | | Сургууль шинжээчийн тайлантай танилцаж хариу өгч, шинжээчийн тайлан эцсийн байдлаар бэлэн болох |
| | | Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр гарах |

| | |
|---|---|
| **Шалгуур шаардлага /журам/** | БМИҮЗ-ийн Удирдах зөвлөлийн 2018 оны 06 дугаар сарын 26-ний өдрийн 08 дугаар тогтоолоор батлагдсан “Шалгуур, шаардлага шинэчлэн батлах тухай” тогтоолын Гуравдугаар хавсралтаар батлагдсан шалгуур шаардлагын дагуу ажиллав. |

**II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга**

**Зорилго:** Гадаад хэлний өндөр мэдлэг, олон улсын харилцааны мэдээ мэдээлэлд дүн шинжилгээ хийх ур чадварыг эзэмшснээр төрийн болон төрийн бус байгууллагад амжилттай ажиллаж чадахуйц мэргэжлийн боловсон хүчин бэлтгэхэд оршино. Тус сургуулийн хөтөлбөрийн зорилго нь тухайн сургуулийн эрхэм зорилго, үндэсний болон олон улсын стандартад нийцсэн чанартай боловсролын үйлчилгээг үзүүлж, хөрвөх чадвартай мэргэжилтэн бэлтгэх уялдааг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн байдаг. Төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын гадаад харилцааны салбарт ажиллах мэргэжилтэнд тавигдах шаардлагад нийцсэн, гадаад хэлний өндөр мэдлэгтэй, бичиг баримт, гэрээ хэлэлцээр боловсруулах чадвартай мэргэжилтэн бэлтгэн гаргахад чиглэгдсэн сургалт явуулдаг.

**Хөтөлбөрийн хүрэх үр дүн PLOs (Program Learninig Outcomes):**

- Шинийг эрэлхийлэх, асуудал шийдвэрлэх, асуудлыг тодорхойлж шинэ санаа гаргах, боломжит хувилбарыг сонгож илэрхийлэн харуулах;
- Шинжлэн судлах, шийдэл гаргах, таамаглал дэвшүүлэн харьцуулсан судалгаа, анализ хийж баримт бичиг боловсруулах;
- Олон улсын харилцааны асуудалд мэргэжлийн сэтгэлгээгээр хандах, хоорондоо хамааралтай зүйлсийг бүхлээр нь олж харах, харилцан хамаарлыг нь ойлгож, ач холбогдлоор нь ангилан чухал санаан дээр төвлөрч, харилцаа хамаарлыг нь нягтлан харьцуулан сонголт хийх;
- Олон улсын харилцаанд гарч буй тулгамдсан асуудлыг онолын үүднээс тайлбарлах
- Гадаад хэлээр харилцах: Англи хэлийг мэргэжлийн түвшинд эзэмшсэн, бусад 1-2 гадаад хэлээр мэдээлэл ашиглах чадварыг эзэмшсэн байх
- Багаар ажиллах чадвар эзэмшсэн байх нь давуу талтай.

Мэргэжилтний эзэмшвэл зохих хандлага:

- Орчин үеийн олон улсын харилцааны чиг хандлагын тухай үндсэн ойлголт, түүнийг ажил мэргэжилдээ, гадаад харилцаанд зөв хэрэглэх
- Харилцааны чадвар эзэмшүүлэх

- Асуудлыг олон талаас нь авч үзэх, илрүүлэх, эргэцүүлэн бодох чадвар эзэмшүүлэх
- Шийдвэр гаргах ур чадвар эзэмшүүлэх
- Аливаа зүйлд чин сэтгэлээсээ хандах зарчим
- Харилцааны соёлыг төгс эзэмшиж, ёс зүйн хэм хэмжээнд суралцах

**Хөтөлбөрийн зорилтууд PEO (Program Educational Objectives):** Олон улсын харилцаа хөтөлбөрийг дээд боловсролын орчин үеийн чиг хандлагын дагуу суралцахуйн үр дүнгийн болон хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлагыг хангах, онол практик хослуулах, суралцагчийн мэргэжлийн ур чадвар болон хувь хүнийг хөгжүүлэх, сургалтын арга зүй, суралцахуйн үр дүн, сургалтын үнэлгээний хэлбэрүүдийг бүрэн багтааж, хөтөлбөрт оролцогч талуудын санал зөвлөмжийг байнга тусган сайжруулж, хичээл хоорондын уялдаа, залгамж холбоог хантан боловсруулсан.

**Хөтөлбөрийн зорилтууд:**

- ✓ Олон улсын харилцааны судалгааны арга зүйг эзэмшсэн, Монгол Улсын хууль тогтоомж болон мэргэжлийн ёс зүйг эрхэмлэсэн багшлах бүрэлдэхүүнтэй байна.
- ✓ Багшлах боловсон хүчнийг судалгаа шинжилгээний ажил хийх, мэргэжлээрээ мэргэших, эрдмийн бүтээл туурвих нөхцөл бололцоог бүрдүүлэх
- ✓ Мэргэжлийн сурах бичиг, гарын авлага, интернэт номын сангийн хүрэлцээ чанарыг шинэчлэж сайжруулж байх
- ✓ Дотоодын их дээд сургуулийн сургалтын шилдэг арга, технологийг нутагшуулах
- ✓ Суралцагчдад суралцах сонирхол, арга зүйг эзэмшүүлэх
- ✓ Хөтөлбөр нь үндэсний болон төр, хувийн хэвшлийн байгууллагад тавигдаж байгаа шаардлагад нийцсэн гэж үзэж байна. Үүнд:
- ✓ Олон улсын харилцаа хөтөлбөрийн шаардлагын дагуу суралцах чадвар бүхий суралцагчдыг элсүүлэх, сургалтын чанар байдалд хяналт тавих, үр дүнг тооцох тогтолцоо механизм бүрдсэн.
- ✓ Сургалтын хөтөлбөрийг шинэчлэх, сайжруулах арга хэлбэр бүрэлдэн тогтсон.
- ✓ Олон улсын харилцаа хөтөлбөрөөр суралцагчдад тавигдаж буй шаардлага түүнийг ханган биелүүлэх асуудлын хүрээнд их дээд сургууль мэргэжлийн болон харилцагч байгууллагуудтай хамтын ажиллагааг өрнүүлэх зорилгоор эрдэм шинжилгээ, онол арга зүйн хурал зөвлөгөөн уулзалт, хэлэлцүүлэг зэрэг арга хэмжээг зохион байгуулдаг.

- ✓ Төгсөгчдийн холбоогоор дамжуулан сургууль, төгсөгчдийн харилцан холбоог бататган тэдний санал бодол, сонирхлыг хөтөлбөрт тусгах арга хэмжээг авдаг.

- ✓ Сургалтын хөтөлбөрийн агуулга, биелэлт, гүйцэтгэл, үр дүнгийн талаар судалгааг үе шаттайгаар хийж, байгууллагын гишүүд үйлчлүүлэгчдийн санал бодлыг тусгах зорилт дэвшүүлэн ажилладаг.

**Хөтөлбөрийн төгсөгчийн загвар:**

1. Гадаад улс оронтой харилцах олон улсын харилцааны онолын суурь мэдлэг
2. Даяаршиж байгаа дэлхий дахинд болж буй үйл явцын талаарх мэдлэг
3. Улс орны гадаад дотоод бодлогын талаарх мэдлэг
4. Олон улсын шинэчлэл, хөгжлийн хандлага, улс төрийн харилцаа, эдийн засаг менежментийн талаарх мэдлэг
5. Мэргэжлийн англи хэлний мэдлэг

**Сургалтын төлөвлөгөөний бүтэц:** Олон улсын харилцаа бакалаврын хөтөлбөрөөр бэлтгэгдэн гарах мэргэжилтэн нь 4 жилийн хугацаанд нийт ерөнхий суурь 37 кредит, мэргэжлийн суурь 31 кредит, мэргэжлийн хичээл 50 кредит, бусад 9 кредит нийт 127 кредит цагийн хичээл судлан, танилцах болон үйлдвэрлэлийн дадлагыг хийж, курсын ажил, дипломын ажил бичдэг. Оюутан тус хөтөлбөрөөр олон улсын харилцааны асуудлууд, төрийн болон дипломат ёслол, дипломат баримт бичгийн талаар онол арга зүй, практикийн мэдлэгтэй, олон улсын тулгамдсан асуудлуудыг судлах арга зүйг эзэмшсэн, харилцааны ба ёс суртахууны өндөр соёлтой, гадаад дотоодын зах зээлд өрсөлдөх чадвар бүхий төрийн, олон улсын, бизнесийн байгууллагын гадаад харилцааны салбарын мэргэжилтэнээр төгсдөг.

| № | | Хичээлийн индекс | Хичээлийн нэр | Багц цаг | Улирал |
|---|---|---|---|---|---|
| **1. ЕРӨНХИЙ СУУРЬ ХИЧЭЭЛ** | | | | **37** | |
| 1 | 1 | SENG116 | Англи хэл I | 3 | 1 |
| 2 | 2 | SENG126 | Англи хэл II | 3 | 2 |
| 3 | 3 | SENG216 | Англи хэл III | 2 | 1 |
| 4 | 4 | SENG224 | Англи хэл IV | 2 | 2 |
| 5 | 5 | SPHE111 | Биеийн тамир | 2 | 2 |
| 6 | 6 | PLAW208 | Хүний эрх | 2 | 1 |
| 7 | 7 | SPOL212 | Дэлхийн газрын зураг | 2 | 1 |
| 8 | 8 | SMRT212 | Маркетингийн үндэс | 2 | 1 |
| 9 | 9 | SMNG112 | Менежментийн үндэс | 2 | 1 |
| 10 | 10 | SLIN113 | Монгол бичиг | 2 | 1 |
| 11 | 11 | JRIS100-2 | Монголын төр эрх зүйн түүх | 2 | 2 |
| 12 | 12 | SCOM122 | Мэдээллийн технологийн хэрэглээ | 2 | 1 |
| 13 | 13 | SSHI123 | Сэтгэлгээний түүх, соёл | 2 | 2 |
| 14 | 14 | IKHZ109 | Их засаг судлал | 2 | 1 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 15 | 15 | SECO112 | Эдийн засгийн онол | 2 | 1 |
| 16 | 16 | SBET312 | Бизнесийн ёс зүй | 2 | 1 |
| 17 | 17 | SIBS213 | Бүс нутаг судлалын үндэс | 3 | 1 |
| **2. МЭРГЭЖЛИЙН СУУРЬ ХИЧЭЭЛ** | | | | **31** | |
| **Б1. ЗААВАЛ СУДЛАХ ХИЧЭЭЛ** | | | | **22** | |
| 18 | 4 | SMDH123 | Монгол улсын гадаад бодлогын үндэс | 3 | 2 |
| 19 | 5 | SINH212 | Олон улсын харилцааны түүх | 3 | 2 |
| 29 | 1 | SJAP116 | Сонгон гадаад хэл -I /Япон, солонгос, хятад хэл/ | 2 | 2 |
| 30 | 2 | SJAP216 | Сонгон гадаад хэл -II /Япон, солонгос, хятад хэл/ | 3 | 1 |
| 21 | 7 | SICR323 | Олон улсын нийтийн эрх зүй | 3 | 2 |
| 22 | 8 | SINF222 | Мэдээлэл технологи ба дипломат ажиллагаа | 2 | 2 |
| 23 | 9 | SIOT322 | Олон улсын байгууллага, олон талт яриа хэлэлцээр | 2 | 2 |
| 24 | 10 | SDIP322 | Дипломат баримт бичиг боловсруулалт | 2 | 2 |
| 25 | | | | | |
| 26 | 12 | SISI312 | Олон улсын хөрөнгө оруулалт | 2 | 1 |
| 27 | | | | | |
| **Б2. СОНГОН СУДЛАХ ХИЧЭЭЛ** | | | | **9** | |
| 28 | 14 | SMGH312 | Монгол улсын эдийн засгийн гадаад харилцаа | 2 | 1 |
| 20 | 6 | SMDH112 | Монгол улсын гадаад бодлого, дипломатын түүх | 3 | 1 |
| 34 | 3 | SUSP402 | АНУ-ын гадаад бодлого | 2 | 1 |
| 44 | 13 | SJPH412 | Япон улсын түүх, гадаад бодлого | 2 | 1 |
| **3. МЭРГЭЖЛИЙН ХИЧЭЭЛ** | | | | **59** | |
| **В1. ЗААВАЛ СУДЛАХ ХИЧЭЭЛ** | | | | **37** | |
| 32 | 1 | SENG312 | Англи хэл V | 2 | 1 |
| 33 | 2 | SCPS312 | Харилцааны сэтгэл судлал | 2 | 2 |
| 31 | 3 | SJAP226 | Сонгон гадаад хэл -III /Япон, солонгос, хятад хэл/ | 3 | 2 |
| 35 | 4 | SCHP412 | БНХАУ-ын гадаад бодлого | 2 | 1 |
| 36 | 5 | SDIP212 | Дипломат ба консулын алба | 3 | 1 |
| 37 | 6 | SRHP402 | ОХУ-ын гадаад бодлого | 2 | 1 |
| 38 | 7 | SSCS222 | Төрийн ёслол, аюулгүй байдал | 2 | 2 |
| 39 | 8 | SPEC412 | Улс төр эдийн засгийн глобалчлал | 2 | 1 |
| 40 | 9 | SCON322 | Хурлын дипломат ажиллагаа | 3 | 2 |
| 41 | 10 | SIPI322 | Олон улсын тулгамдсан асуудлууд | 2 | 2 |
| 42 | 11 | SDIP313 | Дипломат ёслолын албаны онол практик | 3 | 1 |
| 43 | 12 | SDIP401 | Дипломат орчуулга | 2 | 1 |
| 45 | 14 | SPEN222 | Англи хэл VI | 2 | 2 |
| | 11 | SINT222 | Олон улсын харилцааны онол | 2 | 2 |
| | 13 | SGEO312 | Геополитикийн үндэс | 3 | 1 |
| 46 | 15 | SWEC312 | Дэлхийн эдийн засаг | 2 | 2 |
| **В2. СОНГОН СУДЛАХ ХИЧЭЭЛ** | | | | **9** | |
| 47 | 1 | SURO322 | Их гүрнүүдийн гадаад бодлого ба Монгол улс | 3 | 2 |
| 48 | 2 | SJAP316 | Сонгон гадаад хэл -IV /Япон, солонгос, хятад хэл/ | 2 | 1 |
| 49 | 3 | SJAP326 | Сонгон гадаад хэл -V /Япон, солонгос, хятад хэл/ | 2 | 2 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 50 | 4 | SJAP412 | Сонгон гадаад хэл -VI /Япон, солонгос, хятад хэл/ | 2 | 1 |
| **4. БУСАД** | | | | **13** | |
| 51 | 1 | SPRC301 | Курсын ажил | 2 | |
| 52 | 2 | SPRC201 | Танилцах дадлага | 2 | |
| 53 | 3 | SPRC403 | Үйлдвэрлэлийн дадлага | 5 | |
| 54 | 4 | | Сайн дурын ажил | 2 | |
| 55 | 5 | | Нийгмийн идэвхи оролцоо | 2 | |
| 56 | 6 | | Гадаад бодлого, олон улсын харилцаа | | |
| 57 | 7 | | Дипломат албаны онол практик | | |
| 58 | 8 | | Сонгон гадаад хэл -V /Япон, солонгос, хятад хэл/ | | |
| | | | | **127** | |

**Багшлах бүрэлдэхүүний нөөц, чадамж:**

Их засаг Чингис Соосэ сургууль нь Их засаг ОУИС-ийн хөтөлбөрийн хороогоор олон улсын харилцааны сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг батлуулж ирсэн бөгөөд 2021-2022 оны хичээлийн жилээс эхлэн нэршлийн өөрчлөлт хийж тэнхимийн хэлбэрт шилжиж сургалт, хүмүүжлийн үйл ажиллагаагаа дараах бүтэц, зохион байгуулалттайгаар явуулж байна. Үүнд:

1. Тэнхимийн эрхлэгч Б.Доржханд доктор /Ph.D/
2. Тэнхимийн зөвлөх профессор З.Мягмар доктор /Ph.D/
3. Тэнхимийн зөвлөх профессор Б.Батмөнх доктор /Ph.D/
4. Тэнхимийн зөвлөх профессор Д. Батсайхан доктор /Ph.D/
5. Тэнхимийн ахлах багш Б.Гэрэлмаа /Бизнес удирдлагын магистр/
6. Багш Д.Чинбаяр /ахлах багш/
7. Багш Х.Нурсауле /ахлах багш/
8. Багш Д.Ариунчимэг /ахлах багш/
9. Багш Б.Оюун-Эрдэнэ
10. Цагийн багш Б.Бямбаханд
11. Цагийн багш П.Нямбаяр

ОУХ-ны тэнхим нь жил улирлын ажлын төлөвлөгөөг Их засаг ОУИС-ийн жилийн ажлын нэгдсэн графикт ажилтай уялдуулан сургалтын үйл ажиллагааг зохион байгуулдаг.

**Суралцагчдын тоо:** 173

**Төгсөгчдийн тоо гэх мэт хөтөлбөртэй холбоотой мэдээлэл оруулах:** Олон улсын харилцаа хөтөлбөрөөр 981 төгссөн бөгөөд сүүлийн 5 жилийн төгсөгчдийн тоо 111 оюутан байна.

## III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

**Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт**

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

**1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага**

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

**Илрэл нотолгоо:** /шаардлагатай холбоотой тоо баримт, танилцсан мэдээлэл бичнэ/

- ✓ Хөтөлбөрийг БШУ-ны сайдын 2022 оны А/160 дугаар тушаалыг удирдлага болгон боловсруулсан байна.
- ✓ Сургалтын ажил эрхлэх тусгай зөвшөөрөлтэй танилцав. 960058
- ✓ Их засаг их сургуулийн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай тушаал.
- ✓ Их засаг олон улсын их сургуулийн сургалтын журам.
- ✓ Сургалтын программын мэдээллийн кодуудыг журамлан батлах тухай тушаал
- ✓ Хөтөлбөрийн хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай тушаал
- ✓ Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт болон карьер өсөлтийн судалгаа
- ✓ Ажил олгогчийн судалгаа
- ✓ Оюутны сэтгэл ханамжийн судалгаа
- ✓ Багш нарын сэтгэл ханамжийн судалгаа
- ✓ 1234 дүгээр курсийн хичээлийн хөтөлбөр

**Онцлог зүйл:** /Давуу тал, сайн туршлага г.м/

- Оюутнуудын хандлагыг зөв болгох соёл тогтоох төлөвлөгөө боловсруулалт, хэрэгжилт сайн.
- IELTS 4-5, 6-7 оноо хүртэл судлах хичээлүүдийг нэмж оруулсан нь бусад сургуулиас ялгарах, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх сайн талтай.
- Олон улсын харилцааны мэргэжлийн чиглэлээр жил бүр эрдэм шинжилгээний хурал зохион байгуулдаг.

**Анхаарах асуудал:**

Зах зээл дээрх хэрэгцээ шаардлагыг үнэлсэн дүн шинжилгээ хийх

- Олон улсын харилцааны онолын мэдлэгийг чанаржуулах
- Англи хэлний чадварыг нэмэгдүүлэхэд анхаарах
- Солонгос, Орос, Хятадын боловсролын чиг хандлагыг баримжаа болгосон байна. Харин эдгээр улсуудын багшлах боловсон хүчин бараг ихэнх нь барууны боловсрол эзэмшсэн байдгийг бодолцож үзэх.

**Үнэлгээ: /Бүрэн хангасан/**

**Зөвлөмж:**

- Олон улсын харилцааны онолын доктор зэрэгтэй багштай болох
- Англи хэлний ярих, бичих чадварыг олон улсын Англи хэлний шалгалтын стандартад нийцэхээр төлөвлөх

**1.2 Хөтөлбөрийн зорилго**
Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

**Илрэл нотолгоо:** /шаардлагатай холбоотой тоо баримт, танилцсан мэдээлэл бичнэ/

- ИЗОУИС-ийн эрхэм зорилго
- Хөтөлбөрийн эрхэм зорилго
- Хөтөлбөрийн эрхэм зорилготой уялдах зорилтууд

**Онцлог зүйл:** /
Их засаг их сургуулийн эрхэм зорилготой Чингис СООСЭ ОУИС-ын эрхэм зорилго нийцсэн байна

**Анхаарах асуудал:**

- Мэдээ мэдээлэлд дүн шинжилгээ хийх хэмээх эрхэм зорилготой гэдэг нь хөтөлбөрийг явцуу болгох сул талтай
- “Төрийн болон төрийн бус байгууллагад ажиллах мэргэжилтэн бэлдэх” хэмээн компани, олон улсын улсын байгууллага, гадаадын аж ахуй нэгжийг орхигдуулсан.
- Хэрэгжүүлсэн, хийгдсэн ажлуудыг тоочиж бичсэн байна. Зорилт бол ирээдүйд чиглэсэн, зорилгыг хэрэгжүүлэх алхам байх ёстой.

**Үнэлгээ: Хэсэгчлэн хангасан**

**Шаардлага:**

- Хөтөлбөрийн зорилтуудыг тодорхой болгох

**1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд**
Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.

**Илрэл нотолгоо:** /шаардлагатай холбоотой тоо баримт, танилцсан мэдээлэл бичнэ/

- 18 насанд хүрээгүй болон хөгжлийн бэрхшээлтэй оюутанд үйлчилгээ үзүүлэх журам
- Нэгж хичээлийн иж бүрдэл боловсруулах загвар
- Давтлага сургалтын үйл ажиллагааг зохицуулах тухай тушаал
- Сайн дурын ажлын хөтөлбөр, удирдамж
- Танилцах дадлагын удирдамж
- Үйлдвэрлэлийн дадлагын удирдамж
- Курсийн ажил бичих үлгэрчилсэн сэдэв

**Онцлог зүйл:** /Давуу тал, сайн туршлага г.м/

- Сайн дурын ажил хийх дүрэм журам тодорхой.
- Курсийн ажил бичих үлгэрчилсэн сэдвүүд шинэчлэгдсэн, цаг үеийн асуудалтай нийцсэн

**Анхаарах асуудал:/**Сул тал/

- Тогтмол сайжруулах арга замыг илүү тодорхой болгох.

**Үнэлгээ:** /Бүрэн хангасан /

**Зөвлөмж: /**Анхаарах асуудалд чиглэсэн байна/

- Төлөвлөлт, сургалт, үнэлгээ, хэрэгцээ шаардлагын судалгааны дүгнэлт, шинэ төлөвлөгөө зэргээр хоорондын уялдаа холбоог товч тодорхой ойлгомжтой болгох.

**Шаардлага: /Бүрэн хангасан/**

**ШАЛГУУР 1.**
**ШИНЖЭЭЧИЙН ҮНЭЛГЭЭ**: /**Бүрэн хангасан** /

**Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа**
Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

**2.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл**
Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

**Илрэл нотолгоо:** /шаардлагатай холбоотой тоо баримт, танилцсан мэдээлэл бичнэ/

- Сургалтын төлөвлөгөө
- Хичээлийн хөтөлбөрүүдийг шинэчлэн сайжруулах тухай тогтоол
- Хөтөлбөрийн багийн хурлын тэмдэглэлүүд
- Тэнхимийн хурлын тэмдэглэлүүд
- Сургалтын журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай тушаал
- Сургалтын үйл ажиллагаанд зохицуулалт хийх тухай тушаал
- Сургалтыг цахимаар зохион байгуулах түр удирдамж

**Онцлог зүйл:** /Давуу тал, сайн туршлага г.м/

- Суралцагчийн зөв хандлагыг эзэмшүүлэх соёл тогтоож чадсан. /Мэндлэх хүндлэх ёс, багаар ажиллах чадвар, ачаалал даах, цаг барих чадварыг тодорхой хэмжээнд эзэмшүүлж чадсан/
- Суралцагчийн сэтгэл ханамж бүрэн хангагдсан. /Суралцаж буй оюутан, төгсөгч, ажил олгогч, багш, ажилчид бүгд сэтгэл ханамжтай ажиллаж байна/

**Анхаарах асуудал:**/Сул тал/

- Багш нарын мэдлэгт тааруулж хичээлийн агуулга боловсруулах бус хичээлийн агуулагд тааруулж багш нарыг сонгож ажиллуулах шаардлагатай байна.
- Хичээлийн агуулгыг 1-4 дүгээр курс хүртэл логик дарааллын дагуу зөв байршуулах

**Үнэлгээ:** /Бүрэн хангасан/

**Зөвлөмж:** Мэргэжлийн боловсон хүчнийг нэмэх /доктор, профессор зэрэгтэй, англи болон бусад хэлний мэдлэгтэй багштай болох/

- Барууны шилдэг их дээд сургуулийн агуулгыг баримжаа болгох

**2.2 Сургалтын арга зүй**

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

**Илрэл нотолгоо:** /шаардлагатай холбоотой тоо баримт, танилцсан мэдээлэл бичнэ/

- Хичээлийн иж бүрдэл боловсруулах загвар
- Лекцийн конспект

- Семинарын конспект
- Лабораторын конспект
- Мүүдл систем
- Багш нарын үзүүлэх хичээлийн хуваарь
- Үзүүлэх хичээлийн хэлэлцүүлгийн протокол
- Оюутантай ажиллах болон Нээлттэй хичээлийн зохион байгуулалтыг сайжруулах ректорын тушаал
- Их засаг ОУИС-ийн оюутнуудын Сайн дурын ажлын хөтөлбөр, удирдамж
- Суралцагчийн бичих болон ярих чадварыг сайжруулах журам, үнэлэх журам
- Уншсан номын тэмдэглэл шалгаруулах уралдаан тэмцээн зохион байгуулдаг.

**Онцлог зүйл:**
Сургуулийн удирдлагаас хяналт сайтай /Лекц, семинарын бүх агуулга, хэлбэрийг удирдлага баталсны дараа хичээл орох эрх нээгдэнэ, оюутны лекц хөтлөлтийг багш нарын конспекттэй тааруулж шалгадаг/

- Оюутнуудтай харилцах, тэднийг хөгжүүлэх, чадавхжуулах арга хэмжээ олонтой, хэрэгжилт сайн.
- Оюутнуудтай харьцах харьцаа маш сайн.

**Анхаарах асуудал:**

- Мэдээлэл харилцаа холбооны дэвшилтэт технологи ашиглалтыг нэмэгдүүлэх шаардлагатай.

**Үнэлгээ: /Бүрэн хангасан/**

**Зөвлөмж:**
Компьютер, интернэт хэрэглээ, ухаалаг самбар г.м техник хэрэгслээр хангах

**2.3 Суралцагчийн үнэлгээ**
Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

**Илрэл нотолгоо:**
Шалгалтын хэлбэр, асуулт даалгавар, сорилын санд хийсэн шинжилгээ

- Хичээлийн журнал, к-төлөвлөгөө
- Лекц, семинарын хичээл явуулах болон оюутны мэдлэг чадварыг дүгнэх заавар
- Улирлын шалгалтын дүнгийн анализ
- Шалгалтын журам
- Суралцагчийн мэдлэг чадварын үнэлгээ

- Оюутны мэдлэг чадварын үнэлгээ
- Оюутны мэдлэг чадварыг дүгнэх журам
- Оюутны мэдлэг чадварыг дүгнэх заавар
- Улирал дундын шалгалтын асуулт
- Ажлын байрны тодорхойлолт
- Япон Улсад багш судлаачдыг суралцуулах тухай тушаал

**Онцлог зүйл:**

- Их сургуулийн захирал, хөтөлбөр хариуцсан захирал, журнал, к-төлөвлөгөө, оюутны лекцийн тэмдэглэгээтэй тогтмол тулгалт хийдэг.
- Хандлага үнэлэх үнэлгээний аргазүй сайн

**Анхаарах асуудал:**

- Мэдлэгийн үнэлгээг сайжруулах шаардлагатай

**Үнэлгээ:** /**Бүрэн хангасан**/

**Зөвлөмж:**
Олон улсын харилцааны онолын үндсэн мэдлэг, ойлголт, агуулга зэргийг оюутнуудад эзэмшүүлэх, зөв үнэлэх.

**ШАЛГУУР 2.**

**ШИНЖЭЭЧИЙН ҮНЭЛГЭЭ**: /**Бүрэн хангасан** /

**Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл**
Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.

**3.1 Сургалтын орчин**
Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

**Илрэл нотолгоо:** /шаардлагатай холбоотой тоо баримт, танилцсан мэдээлэл бичнэ/

- Дотуур байр 240, багш нарын байр, Чингис СООСЭ ОУИС-ын анги, танхимтай танилцав.
- Автомашины хангалттай зогсоол.
- Биеийн тамирын заал.
- Лекцийн заал хангалттай.

**Онцлог зүйл:** /Давуу тал, сайн туршлага г.м/

- Анги танхимын тохижилт сайн

**Анхаарах асуудал:/**Сул тал/

- Хуучны байр тул бүгчим, чийг үнэртэй, халуун, олон оюутан нэг дор хичээллэх болбол халууцах, агааргүйдэх, хичээл дээр анхаарал алдах магадлалтай

**Үнэлгээ: Бүрэн хангасан**

**Зөвлөмж:**

Анги, танхим бүрийн агааржуулах систем сайжруулах

**3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн**
Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

**Илрэл нотолгоо:**

- Мэдээлэл зүйн танхимд 40 гаруй компьютертой.
- XCLOUD программ ашиглаж байна.

**Онцлог зүйл:** Олон улсын харилцааны хичээлд шаардлагатай газрын зураг, алдартнууд, улс орнуудын онцлог, олон улсын байгууллага зэрэг мэдлэг, мэдээллийг нэг дороос олох боломжтой ханын самбар, зураг, хэрэгсэл сайтай

**Анхаарах асуудал:**

- Оюутнуудын хэлний чадварыг сайжруулахад анхаарах

**Үнэлгээ:** /**Бүрэн хангасан**/

**Зөвлөмж:**

- Лингафоны кабинет байгуулах

**3.3. Номын сан, мэдээллийн эх үүсвэр**
Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

**Илрэл нотолгоо:**

- 800 гаруй мэргэжлийн ном, сурах бичигтэй

**Онцлог зүйл:**

- Олон улсын харилцааны хуучны ховор ном, сурах бичиг сайтай.

**Анхаарах асуудал:**

- Номын сангийн номуудыг хичээлийн агуулгатай уялдуулж ангилах, хичээл тус бүрээр унших номын жагсаалтын дагуу номын санг баяжуулах.
- Англи хэл дээрх сурах бичгийг нэмэгдүүлэх.

**Үнэлгээ: /Бүрэн хангасан** /

**Зөвлөмж:**

- 1573 ширхэг номыг ангилах, төрөлжүүлэх, бүлэглэх
- Барууны шилдэг эрдэм шинжилгээний сэтгүүлийг тогтмол захиалах. /Foreign Affairs гм/

**ШАЛГУУР 3.**

**ШИНЖЭЭЧИЙН ҮНЭЛГЭЭ**: /**Бүрэн хангасан**/

**Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт**

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

**4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа**

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

**Давуу тал:**

Тэнхимийн эрхлэгч нь тэнхимийн ажлын төлөвлөгөөг дараах агуулгаар иж бүрэн гаргаж батлуулдаг. Үүнд:

- Сургалтын төлөвлөгөөг сургалтын нэгдсэн албаар батлуулж батлагдсан төлөвлөгөөгөөр сургалтын хөтөлбөрийг БШУ-ны сайдын А/174, А/348 тоот тушаалд нийцүүлэн ажил олгогч аж ахуй нэгж байгууллагатай хамтран ажиллах гэрээ, хөтөлбөрт ажил олгогчийн санал дүгнэлтийг тусгаж батлуулан тэнхимийн хөтөлбөрийн хавтас бүрдүүлэлт хийдэг.
- Багш нарт сурган заах арга зүйн зөвлөгөө өгөх, багшийн хичээлд сууж зөвлөмж өгөх, багшийн ажлыг шалгах үнэлгээжүүлэх, багш нарын оюутан хөгжүүлэх төлөвлөгөөг батлах, хянах, цогц боловсрол олгох хөтөлбөрийн төлөвлөгөө, багш нарын цагийн ачаалал, ажил үүргийн хуваарь, үзүүлэх хичээлийн хуваарь, журнал хөтлөлт, улирал дундын болон улирлын шалгалтын хуваарь зэргийг гаргах шалгалтын материал боловсруулалт, хэрэгжүүлэлтэд хяналт тавин ажилладаг.

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

**Анхаарах асуудал:**

- Сургалтын чанарт анхаарах
- Сургалтандаа сүүлийн үеийн боловсролын шинэ арга технологийг нэвтрүүлэх бодлого баримтлах

**Шалгуур 4.2 Багшийн нөөц**

Тухайн хөтөлбөрийн мэргэжлийн чиглэл, боловсролын зэргийн түвшинд тохирсон боловсролын зэрэг, эрдмийн цолтой, багшлах өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багш, судлаачийн нөөцтэй байна. Багш, бакалаврын оюутануудын тооны харьцааг зохистой тогтоосон байна.

**Баримт нотолгоо:**

- Багшийн нөөц бүрдүүлэх талаархи бодлогын баримт бичигүүд
- “Олон улсын харилцаа” бакалаврын хөтөлбөрт хичээл заах багшийн судалгаа. Хүснэгт 25. 12 хичээл-8 багш.
- Багш , бакалаврын оюутаны харьцаа1:4.3 байгаа нь боломжийн.
- Хүснэгт 4. 4 Хөтөлбөрийн багаас боловсруулан, хэрэгжүүлж мөрдөж буй дүрэм журам, хэрэгжилт

**Давуу тал:**

- Бакалаврын хөтөлбөр хэрэгжүүлэх багшлах бүрэлдэхүүний нөөцтэй, 80 гаруй хувь дэд проф цолтой,
- Мөрдөгдөх дүрэм журамд нийцүүлж гаргасан багшийн ажил дүгнэх бодлогын баримт бичиг, түүний мөрдөлт сайн хэвшсэн.
- Сургуулийн эрхэм зорилго алсын хараа, бакалаврын хөтөлбөрийн зорилго зорилтуудад нийцүүлж хүний нөөцийн менежментийн тэргүүлэх чиглэлээ тодорхойлж түүнд хүрэх аламмуудаа төлөвлөсөн
- Багшийн өөрийн үнэлгээний төлөвлөгөөний загварыг хөтөлбөрийн зорилтой уялдуулж багшийн хөгжлийн хөтөлбөр, багшийн чадамжийн хүрээг тодорхойлсон.

**Анхаарах асуудал:**

- ОУ-ын чансаа өндөр сэтгүүлд өгүүлэл хэвлүүлэх, дотоодын сэтгүүлд хэвлэгдэж байгаа өгүүлэлд тодорхой стандарт тавих,
- Эрдэм шинжилгээ дээр анхаарах
- Бүтээлийн жагсаалт

**Зөвлөмж:**

- Багшийн нөөцийг бүрдүүлэхдээ аль болох олон сургууль, олон соёлын суурийг харж бүрдүүлэх

**Шалгуур 4.3. Багшлахуйн үнэлгээ**

Багшлахуйн үр дүн,  гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт, үнэлгээний үйл явцыг тодорхой журамлан, хөтөлбөрийн зорилго, зорилтуудад нийцүүлэн багшийн ур чадварыг шударга, бодитой, системтэй, тогтмол үнэлэх тогтолцоо бүрдүүлсэн байна. Мэдлэгт суурилсан үнэлгээний систем нь багшийн байнгын хөгжлийг дэмжихэд чиглэсэн байна.

**Баримт нотолгоо:**

- Багшийн ажлын үнэлгээний журам”-тай.
- Багшийн өөрийн хөгжлийн төлөвлөгөө гаргуулдаг. /хүснэгт 28/
- Багшийн үнэлгээний “2017 оны журам”  нь гүйцэтгэлийн үнэлгээг шалгах, ”хөндлөнгийн үнэлгээ хийхэд ашиглагддаг. Үнэлгээнд 3 талын:а/ удирдлага, б/суралцагч, в/ багшийн оролцоог хангадаг. / хүснэгт 29/.

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

**Давуу тал:**

- Багшийн ажлын үр дүнг үнэлэх бодолгын баримт бичигтэй,түүнийгээ хатуу мөрдөж ажилладаг

**Шалгуур 4.3 Багшийн хөгжил**

Багш нар мэргэжлийн болон багшлах ур чадвараа дээшлүүлэх, судалгаа шинжилгээ хийх,  бакалаврын судалгаа удирдах ур чадвараа ахиулахад нь чиглэсэн үйл ажиллагааг системтэй хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй, боловсролын үйлчилгээнд шинэ арга зүй, инновац нэвтрүүлэхийг дэмжин урамшуулах бодлого, журамтай байна

**Баримт нотолгоо:**

- “Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль”,”багшийн хөгжлийн хөтөлбөр”-ийг дагаж мөрддөг.
- ”Багшийн хөгжлийн төвийг шинэчлэн байгуулж ажиллуулж байгаа.
- Журам, э/ш ажлын үр дүнг дээшлүүлэх зарим арга хэмжээний тухай” баримт бичгүүдтэй  багшийн хөгжлийг уялдуулдаг. Хүснэгт 30-д багшийн хөгжлийн хүрээг бодитоор тодорхойлж өгсөн.

- Академик чадамжаас техник технологийн чадамж гэсэн 6 зүйл чадамжийн хүрээ,шалгуууртай.

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**
**Давуу тал:**

- Багшийн хөгжлийг хангах бодолгын баримт бичиг, түүний хэрэгжилтийг хангах бодит орчим, дүрэм, журмыг иж бүрнээр бүрдүүлсэн

**Анхаарах асуудал:**

- Багш нарын эрдэм шинжилгээний ажлын чанарыг цаашид улам сайжруулж олон улсын чансаа өндөр сэтгүүлд бүтээл олныг гаргахад анхаарах

**Зөвлөмж:**

- Багшийн хөгжлийн бодит өсөлтийг хангахдаа гарааны цэгийн үзүүлэлтийг тодорхой тэмдэглэж бэхжүүлэх

**Шалгуур 4.4  Судалгаа ба хөгжил**

Багш нар хөтөлбөрийн судлагдахуунтай холбоотой судалгааны ажлыг идэвхтэй хийх, шаардлагатай тохиолдолд судалгааны баг бүрдүүлж, бакалаврын судалгаанд татан оролцуулах боломжийг бүрдүүлсэн байна.

**Баримт нотолгоо:**

- Сургуулийн хэмжээний бодолгын баримт бичгүүдтэй уялдуулан шинээр нээж буй хөтөлбөрийн зорилго, зорилтууд тодорхойлогдож энэ хүрээндээ судалгааны баг бүрдүүлж өөрийн үнэлгээний тайлан дээр ажиллуусан.
- Одоо байгаа хөтөлбөрүүдийн хэрэгжилт, ялагуяа судалгааны ажилд оюутануудыг татан оруулдаг сайн туршлагаа шинэ хөтөлбөрт хэрэгжүүлэх итгэл үнэмшил хөтөлбөрийн багт бүрдсэн, үүнийг нь сургуулийн зүгээс бүх талаар дэмжиж буй нь сургууль дээр хийсэн уулзалт, ярилцлагаас харагдсан

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан.**
**Давуу тал:**

- Энэ хүрээнд олон жилийн туршлага хуримтлуулсан, шинэ хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хичээл заах проф- багш нар мэргэжлийн байгууллагуудад ажиллаж байсан практик туршлагатай

**Анхаарах асуудал:**

- Багш нарын судалгааны ажлын туршлагыг нэмэгдүүлж магистрант дагуулан судалгаа хийх тэргүүлэх чиглэлийг тодорхойлж тусгай стратеги төлөвлөгөө гарган ажиллах

**Зөвлөмж:**

- Олон улсын харилцаа хөтөлбөрийн хүрээн дэх судалгааны тэргүүлэх чиглэлийг тогтоох

**ШАЛГУУР 4.**

**ШИНЖЭЭЧИЙН ҮНЭЛГЭЭ**: **/Бүрэн хангасан/**

**Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа**

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог хангаж бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

**5.1. Суралцагч сонгох, элсүүлэх**
Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

**Илрэл нотолгоо:** Боловсрол шинжлэх ухааны сайдын 2013 оны 3 сарын 18 ны өдрийн Й/79 тоот тушаал " Оюутан элсүүлэх журам "- нд Боловсрол шинжлэх ухааны сайдын 2018 он 4 сарын 6 ний өдрийн баталсан А/ 195 тоот тушаалд нийцүүлэн элсэлтийн журам боловсруулан тус журмын дагуу элсэлтийн үйл ажиллагааг явуулдаг.

**Онцлог зүйл:**

- Сургуулийн веб сайтад мэдээллүүд нээлттэй дэлгэрэнгүй тусгагдсан батлагдсан тодорхой журмын дагуу элсэлтийн үйл ажиллагааг зохион байгуулдаг
- Шинэ суралцагчдад зориулсан мэдээ мэдээлэл хангалттай гарын авлагатай. / Англи хэл дээр орчуулагдсан/
- Олон улсын харилцаа мэргэжлээр элссэн оюутны тоо сүүлийн 5 жилийн байдлаар тогтвортой үзүүлэлттэй байна.

**Үнэлгээ: /Бүрэн хангасан /**

**5.2. Зөвлөн туслах үйлчилгээ**

Суралцагчид суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол, чанартай үзүүлдэг байна.

**Илрэл нотолгоо:**

- Оюутанд чиглэсэн сургалт, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, хууль эрх зүйн, сэтгэл зүйн болоод эрүүл мэндийн зөвлөгөө зэрэг зөвлөн туслах үйлчилгээ үзүүлдэг.
- Оюутанд зөвлөн туслах үйл ажиллагааны хүрээнд хэрэгжүүлж байгаа зөвлөгөө, хөтөлбөрүүд болох: цогц боловсрол олгох, бие даалтын ажилд зөвлөгөө өгөх, амжилт ахиулах, гадаад улс оронд цалинтай дадлагажигч зэрэг хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг.

**Онцлог зүйл:** /Давуу тал, сайн туршлага г.м/

- Оюутанд чиглэсэн зөвлөн туслах үйлчилгээг хэрэгжүүлэхдээ хичээлийн жилийн нэгдсэн төлөвлөгөө график гарган боловсруулан баталж түүний дагуу зөвлөгөө өгөх ажлууд хийгддэг.
- Багш болгон оюутанд 7 хоногт графикийн дагуу тогтсон өдөр цагт зөвлөгөө өгч ажилладаг.
- Оюутнуудаас сэтгэл ханамжийн судалгаа авдаг.

**Үнэлгээ: /Бүрэн хангасан/**

**5.3. Суралцагчийн олон нийтийн оролцоо, урамшууллын тогтолцоо**

Суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, сайн дурын ажлыг дэмжиж хамтран ажилладаг байна.

**Илрэл нотолгоо:**

Оюутнуудын өөрсдийн хүсэл сонирхол, үзэл бодол, авьяас чадвараараа нэгдэн оюутны үүсгэл санаачилгаар байгууллагууд байгуулан ажиллахыг сургуулийн зүгээс дэмжин ажилладаг.

Оюутнуудад зориулсан олон нийтийн 10 үйл ажиллагаа, сайн үйлсийн аян, мөн сургалт судалгаа, олимпиад, илтгэл эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах чиглэлээр 6 , эрүүл мэндийн чиглэлээр 3 үйл ажиллагааг зохион байгуулдаг.

Оюутнуудыг сайн дурын ажил хийхийг дэмжиж 45 цагийн хөдөлмөрийг 2 кредитэд бодож тооцдог.

Сүүлийн 5 жилийн байдлаар ОУХ хөтөлбөрөөр нийт 81 оюутан хөнгөлөлтөд хамрагдсан. Үүнд: 100 % -д 26, 70 %-д 1, 50 %-д 29, 20 %- д 6, 10%- д 9 оюутан тус тус хамрагдсан байна.

Оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газартай хамтран оюутнуудын ажил эрхлэлтийг дэмжиж ажилладаг. Сүүлийн 5 жилээр 46 оюутанд цагийн ажил эрхлэхэд зуучлан дэмжлэг үзүүлсэн.

**Онцлог зүйл:** /Давуу тал, сайн туршлага г.м/

- Хөнгөлөлт эдэлсэн оюутны тоо сүүлийн жилүүдэд / 2 жилд / өсөх хандлагатай болсон.
- Оюутанд чиглэсэн олон клубүүд үйл ажиллагаа явуулдаг.
- Суралцагчийн судалгааны ажил хийх онол, практикийн талаас дөртэй болгоход өргөн цар хүрээтэй төрөл бүрийн арга аргачлалыг эзэмшүүлэх ажил хийгддэг.
- Оюутнуудын хэлний мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор Англи, Япон, Солонгос хэлний сонгон 7 хоног бүр хичээллэдэг.

**5.4. Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн**

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

**Илрэл нотолгоо:**

Мэргэжлийн чиглэлээр бусад их, дээд сургуулиас шилжин ирж байгаа суралцагчийг бүртгэн авах, түүнтэй холбогдон үүссэн бусад харилцааг Их засаг ОУИС-д шилжүүлэн суралцуулах журмаар зохицуулдаг.

Сүүлийн 5 жилд элсэгчдийн тоо 215, төгсөгчдийн тоо 111 байна. Сүүлийн 5 жилийн байдлаар 104 оюутан шилжилт хөдөлгөөн хийсэн бөгөөд жилд дунджаар ОУХ хөтөлбөрөөр суралцаж буй 20 оюутан жилийн чөлөө авах, гарах, шилжих хөдөлгөөн хийдэг байна.

**Онцлог зүйл:** /Давуу тал, сайн туршлага г.м/

- Элсэлтийн журмыг үндэслэн элсэлтийн үйл ажиллагааг зохион байгуулдаг.
- Хамтын ажиллагаатай байгууллагуудтай төгсөгчдийн ажил эрхлэлт болон суралцагчдын дадлагын баазаар хамтран ажилладаг

**Үнэлгээ: /Бүрэн хангасан/**

**5.5. Төгсөлтийн баримт бичиг**

Төгсөлтийн баримт бичиг нь оюутны мэргэшил, хувь хүний гүйцэтгэл, хөтөлбөрийн үр дүн, эзэмшсэн агуулга, түвшин зэргийг тусгасан байна.

**Илрэл нотолгоо:**

Төгсөгчдөд бакалавр, магистрын диплом, хавсралт олгохдоо БСШУС-ын 2012 оны 01 тоот тушаалыг баримталдаг. Бакалаврын дипломын голч дүн 2,0 -с доош тохиолдолд бакалаврын зэрэг олгохгүй бөгөөд тухайн мэргэжлийн хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан хичээлүүдийг судалсныг гэрчлэх бичиг баримт олгодог.

Бакалаврын зэргийн дипломын загварыг баримтлан кирилл, англи, уйгуржин монгол хэл дээр хувилдаг. Бакалаврын зургийн дипломыг БШУЯ -аас олгосон

дипломын дугаар бүхий удирдах зөвлөлийн дарга, захирал, төгсөлтийн шалгалтын комиссын даргын гарын үсэг сургуулийн тамаг тэмдгээр баталгаажуулдаг.

**Үнэлгээ: /Бүрэн хангасан/**

**ШАЛГУУР 5.**
**ШИНЖЭЭЧИЙН ҮНЭЛГЭЭ**: **/Бүрэн хангасан/**

**Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа**

Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.

**6.1. Багшийн сонгон шалгаруулалт, зэрэглэл, урамшууллын бодлого**
Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

**Илрэл нотолгоо:**

ОУХ -ны хөтөлбөрийн зорилго, зорилтод нийцүүлэн мэргэжлийн өндөр ур чадвартай онол, дадлагыг эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой сургалт судалгааны арга зүйн өндөр чадвартай багш нарыг “ Их засаг ОУИС-д багш ажилтан сонгон шалгаруулж авах журам”, “ Багш ажилтны ажлын байрны тодорхойлолт” зэрэг холбогдох дүрэм, журамд нийцүүлэн багш суралцагчдын тоон харьцаа, цагийн ачаалал зэрэгт үндэслэн хүний нөөцийн албаар шийдвэрлэдэг.

ИЗЧСС-д магистр болон түүнээс дээш зэрэгтэй багшлах эрхээ баталгаажуулсан багш ажиллах эрхтэй бөгөөд сонгон шалгаруулалтад тэнцсэн багш нар нь тухайн хичээлийн жилийн эцэст үр дүнгийн тайланг хэлэлцүүлэн журмын дагуу дүгнүүлж хөдөлмөрийн гэрээг сунгадаг.

Багш нарын боловсролын зэрэг доктор 10, магистр 18 нийт 18 багш ажиллаж байна. Үүнээс: дэд профессор -6, ахлах багш – 13, багш- 8, дадлагажигч багш-1 байна.

**Онцлог зүйл:** /Давуу тал, сайн туршлага г.м/

- Багшлах боловсон хүчний 34 хувь нь докторын зэрэгтэй байна.
- Багш нарын 70 хувь нь 10-аас дээш жил тогтвортой ажилласан.

**Үнэлгээ: /Бүрэн хангасан /**

**6.2. Багшийн хөгжил**

Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.

**Илрэл нотолгоо:**

Багшийн тасралтгүй хөгжлийг удирдлагын бүх шатанд нэгдсэн бодлогоор дэмжихдж, багшийг хөгжүүлэх байгууллагын соёлыг төлөвшүүлэх;

Багш нарын судалгааны түвшинг олон улсын жишигт хүргэх шаардлагат нийцүүлэн судалгааны чадамжийг хөгжүүлэх;

Багшлахуйн цогц чадамж, чадавхыг нэмэгдүүлэх сургах суралцах үйл ажиллагааг шинэ шатанд гаргах;

Багшлах бүрэлдэхүүнийг чадваржуулах, эрдэмжүүлэх, ажиллах орчин нөхцөлийг сайжруулах, сургалтын үйл ажиллагааг үнэлэх шударга тогтолцоо механизмыг тогтоон хэвшүүлэх үүднээс 2020-2025 онд эдгээр зорилтуудыг тавин ажиллаж байна.

**Онцлог зүйл:**

- Багшийн хөгжилд ЭШ-ийн ажилд 3 сарын хугацаатай цалинтай чөлөө олгодог.
- Магистрантур болон докторантурт суралцаж байгаа багш нарт сургалтын төлбөрийн 30 хүртэлх хувь гэх зэрег хөнгөлөлт дэмжлэгийг үзүүлдэг.
- Сургуулийн зүгээс багшийг дэмжих дэмжлэг, урамшуулал нь сүүлийн 5 жилд бүх багш нарыг жигд хамарсан байна.

**Үнэлгээ: /Бүрэн хангасан/**

**6.3. Эрдэм шинжилгээ, судалгаа**

Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.

**Илрэл нотолгоо:**

Эрдэм шинжилгээ судалгааны ажлыг дэмжих үүднээс “Их семинар” эрдэм шинжилгээний хурал жил бүр зохион байгуулагддаг. Шалгарсан багш нар “Багшийн хөгжил-XXI” сэдэвт ЭШХ – д оролцох боломжтой болдог төдийгүй “ИХ ЗАСАГ” сэтгүүлд илтгэлээ хэвлүүлэн багш ажилчдыг дэмжих журмын дагуу Б цагийг тооцож, цалингийн нэмэгдэл олгодог.

Багш судалгаа шинжилгээний ажил хийх, боловсрол болон мэргэжлийн зэргээ ахиулах, мэргэших, ном сурах бич, бүтээл туурвих төсөл хөтөлбөрт оролцох зэрэгт судалгаа шинжилгээ хийхэд сургуулийн зүгээс дэмжин ажилладаг.

**Онцлог зүйл:**

- Сургуулийн зүгээс багш нарт олон талаар дэмжлэг үзүүлдэг. Үүнд: Тесолын сургалт, гадаад улс оронд мэргэшил дээшлүүлэх сургалт, олон улсын чанартай тэмцээн уралдаан, семинар, гадны улс оронд зохион байгуулагдах ЭШХ, гадаад оронд аялах зэрэгт тодорхой хувиас 100 хувь хүртэлх дэмжлэгийг үзүүлдэг.

- Эрдэм шинжилгээ судалгааны ажил гүйцэтгэх, мэдээлэл олж бүрдүүлэх зэрэгт тус дөхөм үзүүлэх зорилгоор нийт багш нар 7 хоногт 1 өдөр, эрдмийн зэрэг хамгаалж байгаа багш нарт 2 өдөр, доктор багш нарт 3 хүртэлх өдрийг эрдэм судлалын ажилд зарцуулахыг сургуулийн дүрэм журамд тусгасан.

**Үнэлгээ: /Бүрэн хангасан /**

**Зөвлөмж:**

- Цаашид чансаа өндөртэй сэтгүүлд судалгааны чиглэлээрээ эрдэм шинжилгээний өгүүлэл нийтлүүлэх
- Төсөл хөтөлбөр дээр ажиллах

**6.4. Багшийн үнэлгээ**

Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байна.

**Илрэл нотолгоо:**

Багшийн ажлын гүйцэтгэлийг ОУИС-иас гаргасан хөдөлмөрийн гэрээний биелэлтийн дагуу үнэлж дүгнэдэг.

Сургалтын нэгдсэн албанаас багш нарын ажлыг үнэлэхдээ заах арга барилтай холбоотой санал асуулгыг оюутнуудаас авч үр дүнг нэгтгэдэг.

Гүйцэтгэлийн болон чанарын үнэлгээнд суурилан багш нарыг үнэлэх, дүгнэх аргачлалтай. ОУИС-ийн дүрмийн 45.9 т заасныг үндэслэн ректорын 2011 оны 9 сарын 6 ний өдрийн 1/13 тоот тушаалаар ажлын гүйцэтгэлийн үнэлгээний баг байгуулагдсан.

Ректорын 2012 оны 3 сарын 9 ний 1/214 тоот тушаалын хавсралтаар “ дотоод хяналтыг зохион байгуулах журам” батлагдаж журамд зааснаар хяналт шалгалтыг АГҮБ хариуцан явуулдаг.

**Онцлог зүйл:**

Багшид хөндлөнгийн үнэлгээг суралцагч, удирдлага, багшийн зүгээс хийдэг.

Багш бүр багш хөгжлийн дэвтэр хөтөлдөг.

Багш нарыг аттестатчилалд 2 жил тутамд хамруулдаг.

Багшийг үнэлэх шалгуур үзүүлэлт, үнэлгээ нь тодорхой

**Үнэлгээ: /Бүрэн хангасан/**

**Зөвлөмж:**

Багшийг хөндлөнгөөс үнэлэх оюутны үнэлгээнд тухайн оюутанг өөрөөр нь тухайн хичээлд хэрхэн оролцоотой байсныг давхар үнэлүүлэх асуулга оруулах

**ШАЛГУУР 6.**

**ШИНЖЭЭЧИЙН ҮНЭЛГЭЭ**: /**Бүрэн хангасан**/

**Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажуулалт**

Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн дотоод чанарын баталгаажуулалтын механизмтай, хөндлөнгөөс үнэлүүлдэг байна.

**Шалгуур 7.1** Чанарын дотоод баталгаажуулалт ба хөтөлбөрийн сайжруулалт

Хөтөлбөрийн хэрэгжилтийг бүхэлд нь болон үе шат бүрийг, түүнчлэн бүрэлдэхүүн хэсэг (хичээлийн хөтөлбөрүүд, суралцахуйн орчин, багшлахуй ба суралцахуйн үнэлгээ, элсэлт, төгсөлт гэх мэт) тус бүрийг байнга, тогтмол давтамжтайгаар хянан үнэлэх, тухай бүр сайжруулах чанарын дотоод баталгаажуулалтын тогтолцоог төлөвлөж, хэрэгжүүлэх бэлтгэлийг хангасан байна. Чанарын дотоод баталгаажуулалтын бүтэц, үйл явцад бүх талын оролцдоог хангана.

**Баримт нотолгоо:**

- ИЗОУИС-ийн үйл ажиллагааны дотоод хяналт, чанарын баталгаажуулалтын гарын авлага
- ИЗОУИС-ийн хөтөлбөрийн чанарын баталгаажуулалтын систем
- ИЗОУИС-ийн ректорын 2017 оны А/86 тоот тушаал “Ажлын гүйцэтгэлийн үнэлгээг шалгах журам”, Ажлын гүйцэтгэлийн багийн бүтэц, бүрэлдэхүүн,
- Ажлын гүйцэтгэлийн багийн үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан
- Хөтөлбөрийг боловсруулахад оролцогч талуудаас авсан судалгааны тайлан

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

**Давуу тал:**

- Хөтөлбөрийг хэрэгжилтийг хангахад чанарын дотоод баталгаажуулалтын тогтолцоог бүрдүүлэхэд баримтлах стратегийг тодорхойлсон
- Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн дотоод болон хөндлөнгийн чанарын баталгаажуулалтын тогтолцоог бүрдүүлэн, холбогдох дүрэм, журмыг баталсан
- Хөтөлбөрийн баталгаажуулах үйл ажиллагааны оролцогч талуудыг тодорхойлсон
- Чанарын баталгаажуулалтыг хангах “Ажлын гүйцэтгэлийн баг”-ийн гүйцэтгэх үйл ажиллагааг журамласан

**Анхаарах асуудал:**

- Сургалтын үйл ажиллагааны чанарт тавих хяналт-шинжилгээ, үнэлгээний үйл явц нь бусад үйл явцын зураглалууд (багшийн хөгжил, суралцагчийг дэмжих, зөвлөх үйлчилгээ зэрэг)-тай холбох

**Зөвлөмж:**
- Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалтын удирдлага, зохион байгуулалтын хангах бодлого, журам, процесс батлах үйл явцын зураглалыг гаргах,
- Хөтөлбөрийн чанарыг сайжруулах зорилгоор үндэсний болон олон улсын тэргүүлэх судлаач, эрдэмтдийг хөтөлбөрт урьж ажиллуулах боломжийг бүрдүүлсэн байна.

**Шалгуур 7.2. Чанарын хөндлөнгийн үнэлгээ ба магадлан итгэмжлэл**
**Хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлснээс хойш жил бүр хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн шалгуурын дагуу өөрийн үнэлгээ хийж, үндэсний болон олон улсын нийтлэг жишигт хүрэхийг эрмэлзэж ажилладаг.**

**Баримт нотолгоо:**
- Ази номхон далайн бүсийн чанарын сүлжээний гишүүн
- Их Британийн Үндэсний магадлан итгэмжлэх зөвлөлөөр олон улсад магадлан итгэмжлэгдсэн
- Хөтөлбөрт оролцогч талуудын оролцоонд тулгуурласан чанарын баталгаажуулалтын механизм
- Бусад хөтөлбөрийн гаргасан амжилтууд
- “Олон улсын харилцаа” бакалаврын сургалтын хөтөлбөрийн чанарын баталгаажуулалтын төлөвлөлт
- Хамтын ажиллагааны 2 талын гэрээ, хэлэлцээрүүд

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**
**Давуу тал:**
- ИЗОУИС-д хөндлөнгийн чанарын баталгаажуулалтын үйл ажиллагаа тогтмолжсон
- Олон улсын мэргэжлийн байгууллагаар хөндлөнгийн үнэлгээг тогтмол хийлгэдэг
- Хөтөлбөр хэрэгжүүлэлтийн зорилго, болон хэмжүүр үзүүлэлтүүдийг нарийвчлан тодорхойлсон

**Анхаарах асуудал:**
- Дотоод чанарын баталгаажуулалтын тогтолцоог үнэлэх, хөгжүүлэх

**ШАЛГУУР 7.**

**ШИНЖЭЭЧИЙН ҮНЭЛГЭЭ**: /**Бүрэн хангасан /**

## Г. ШИНЖЭЭЧИЙН БАГИЙН НЭГДСЭН ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ:

**Дүгнэлт:**

1. Олон улсын харилцааны сургалтын хөтөлбөрийг Монгол Улсын дээд боловсролын хууль эрх зүй, хөтөлбөрт тавигдах шаардлага, БМИҮЗ-өөс гаргасан хөтөлбөрийг магадлан итгэмжлэх шалгуур, шаардлага болон Их засаг ОУИС-ийн бодлогын баримт бичгүүдтэй нийцүүлэн боловсруулсан.

2. Улс төр, нийгмийн салбарын хөгжлийн ирээдүйн төлөв, оролцогч, сонирхогч талуудын эрэлт хэрэгцээнд тулгуурлан хөтөлбөрийн хэрэгцээ шаардлагыг судалж, ирээдүйд шаардагдах шинэ ур чадваруудыг хөтөлбөрт тодорхой хэмжээнд тусгахыг хичээсэн.

3. Олон улсын харилцаа хөтөлбөрийг дээд боловсролын орчин үеийн чиг хандлагын дагуу суралцахуйн үр дүнгийн болон хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлагыг хангах, онол практик хослуулах, суралцагчийн мэргэжлийн ур чадвар болон хувь хүнийг хөгжүүлэх, сургалтын арга зүй, суралцахуйн үр дүн, сургалтын үнэлгээний хэлбэрүүдийг бүрэн багтааж, хөтөлбөрт оролцогч талуудын санал зөвлөмжийг байнга тусган сайжруулж, хичээл хоорондын уялдаа, залгамж холбоог хангаан боловсруулсан.

4. Бакалаврын хөтөлбөрөөр төгсөгчийн загварыг хүний нөөцийн салбарын эрэлт, хэрэгцээ, шаардлагыг хангахуйц үр дүнд суурилсан асуудал шийдвэрлэх ур чадвартай, судлаач-мэргэжилтэн байхад түлхүү анхаарч боловсруулсан.

5. Сургалтын хөтөлбөр, сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөрүүдийн уялдаа холбоог нарийвчлан гаргахад анхаарч хөтөлбөрийг боловсруулсан байна.

6. Монгол улсад мөрдөгдөж байгаа боловсролын тухай хууль, дүрэм, журам, сургуулийн эрхэм зорилго, алсын хараа, стратегийн зорилтуудын хүрээнд, сургуулийн сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх, түүний хэрэгжилтэнд хяналт тавих, сургалтын өдөр тутмын үйл ажиллагааг бодлогоор ханган удирдаж, сургалтын чанарыг сайжруулахад анхаарч ажилладаг.

7. БСШУС-ын 2007 оны 401 тоот тушаалаар батлагдсан “Дээд боловсролын сургалтын байгууллагын үлгэрчилсэн дүрэм батлах тухай” , БСШУС-ын 2014 оны А/78 тоот тушаалаар батлагдсан “Дээд боловсролын сургалтын байгууллагад мөрдөх бакалаврын мэргэжлийн чиглэл /хөтөлбөр/индекс шинэчлэн батлах тухай, БШУС-ын 2014 оны А/174 тоот тушаалаар батлагдсан “Бакалаврын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлага, БШУС-ын 2021 оны А/348 тоот тушаалын “Дээд боловсролын зэрэг олгох сургалтад багц цагийг хэрэглэх, дүйцүүлэх, суралцагчдын

мэдлэг, чадвар, хандлагыг үнэлэхэд баримтлах үлгэрчилсэн журам” болон Их засаг ОУИС-ийн “Сургалтын журам” зэрэгт үндэслэн хөтөлбөр үр дүнтэй хэрэгжих эрх зүйн орчин бүрдсэн.

8. Хөтөлбөрөөр суралцагч суралцахуйн зорилтот үр дүнд хүрэхэд чиглэсэн ил тод, шударга үнэлгээний системийг бүрдүүлсэн.

9. Хөтөлбөрөөс гадуур суралцагчийн бие даан эзэмшсэн багц цагийг дүйцүүлэн тооцох журамтай байна.

10. Суралцагчдыг амжилттай суралцах, хөгжиж төлөвшихөд нь дэмжих, зөвлөх үйлчилгээг системтэйгээр үзүүлэх нөөцийг бүрдүүлсэн байна. Суралцагчдад суралцахуйн зорилтот үр дүнд амжилттай хүрэхэд зөвлөн туслах профессорын баг бүрдсэн.

11. Гадаад хэлний өндөр мэдлэг, олон улсын харилцааны мэдээ мэдээлэлд дүн шинжилгээ хийх ур чадварыг эзэмшснээр төрийн болон төрийн бус байгууллагад амжилттай ажиллаж чадахуйц мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх зорилготой.

12. Олон улсын харилцаа хөтөлбөрийг хэрэгжүүлэх багшлах бүрэлдэхүүний хангалттай нөөцтэй, ажилласан ажлын туршлагатай, багш нарын 80 гаруй хувь нь дэд профессор цолтой.

13. Дээд боловсролын байгууллагад мөрдөгдөж буй дүрэм журамд нийцүүлж гаргасан багшийн ажлыг үнэлж дүгнэх бодлогын баримт бичгүүдийг боловсруулсан.

14. Багшийн хөгжлийн асуудлын хүрээнд багш бүр мэргэжлийн холбоодод түшиглэсэн сургалт, семинар, төсөлд оролцох, олон улсын чансаа өндөр сэтгүүлд өгүүллээ хэвлүүлэхийг зорьж байна.

15. Бакалаврын сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх сургалтын орчинг сайн бүрдүүлсэн.

16. Хөтөлбөрийг чанартай, хүртээмжтэй, тогтвортой, суралцагчдад ээлтэй байлгах үүднээс сургалтын гол хэрэглэгдэхүүн болох ном, сурах бичгийн баяжилтыг шинэчлэх, олон улсын нэр хүнд бүхий эрдэм, шинжилгээ, судалгааны сангийн эрхийг авах зэрэг ажлуудыг эхний ээлжинд шийдвэрлэхээр төлөвлөсөн байна.

17. Их засаг ОУИС нь Олон улсын харилцаа хөтөлбөрийн зорилгодоо хүрэхэд нийцсэн засаглал ба удирдлагын тогтолцоо бүрэн бүрдүүлж, удирдлагын мэдээллийн системийн хөгжүүлэлтийг тасралтгүй хийж ажиллаж байна.

18. Хөтөлбөрийн танилцуулга, элсэгчид тавих шаардлага, сургалтын төлөвлөгөөний бүтэц, хичээлийн хөтөлбөрүүд, суралцах ачаалал, багц цаг, суралцахуйн үнэлгээний аргачлал зэрэг хөтөлбөртэй холбоотой үнэн зөв мэдээллийг багш, суралцагчид, олон нийтэд нээлттэй хүргэх тогтолцоог бүрдүүлсэн, цаашид сайжруулах талаар анхааран ажиллаж байна.

19. Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн дотоод болон хөндлөнгийн чанарын баталгаажуулалтын тогтолцоог төлөвлөсөн байна.

20. Чанарын дотоод баталгаажуулалт ба хөтөлбөрийн сайжруулалтыг хэрхэн хийх талаар үйл ажиллагаа төлөвлөгөө боловсруулсан.

21. Хөтөлбөрийн гүйцэтгэлийн чанарын үзүүлэлтийг боловсронгуй болгох, үйл явцын хяналтын чанарыг сайжруулах замаар чанарын дотоод баталгаажуулалтын тогтолцоог сайжруулахаар ажиллаж байна.

| Шалгуур | | Бүрэн хангасан (2) | Хэсэгчлэн хангасан (1) | Хангаагүй (0) |
|---|---|---|---|---|
| 1 | Хөтөлбөрийн төлөвлөлт | 2 | | |
| 2 | Сургалтын үйл ажиллагаа | 2 | | |
| 3 | Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл | 2 | | |
| 4 | Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт | 2 | | |
| 5 | Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа | 2 | | |
| 6 | Багшийн үйл ажиллагаа | 2 | | |
| 7 | Чанарын үнэлгээ, баталгаажуулалт | 2 | | |
| **Дүгнэлт** | | **Бүрэн хангасан** | | |

## НЭГДСЭН ЗӨВЛӨМЖ, ШААРДЛАГА

/Нэгдсэн зөвлөмжид дээрх зөвлөмж, шаардлагыг шууд тусгахгүйгээр агуулгыг нэгтгэн сургуулийн удирдлага, хөтөлбөрийн баг бодитой хэрэгжүүлж, үр дүнд хүрэх боломжтойгоор томьёолж боловсруулсан байна./

| Шалгуур | Зөвлөмж |
|---|---|

| | | |
|---|---|---|
| 1 | Хөтөлбөрийн төлөвлөлт | • Олон улсын харилцааны онолын доктор зэрэгтэй багштай болох<br>• Англи хэлний ярих, бичих чадварыг олон улсын Англи хэлний шалгалтын стандартад нийцэхээр төлөвлөх<br>• Төлөвлөлт, сургалт, үнэлгээ, хэрэгцээ шаардлагын судалгааны дүгнэлт, шинэ төлөвлөгөө зэргээр хоорондын уялдаа холбоог товч тодорхой ойлгомжтой болгох |
| 2 | Сургалтын үйл ажиллагаа | • Мэргэжлийн боловсон хүчнийг нэмэх /доктор, профессор зэрэгтэй, англи болон бусад хэлний мэдлэгтэй багштай болох/<br>• Барууны шилдэг их дээд сургуулийн агуулгыг баримжаа болгох<br>• Олон улсын харилцааны онолын үндсэн мэдлэг, ойлголт, агуулга зэргийг оюутнуудад эзэмшүүлэх, зөв үнэлэх. |
| 3 | Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл | • Анги, танхим бүрийн агааржуулах систем сайжруулах<br>• Лингафоны кабинет байгуулах<br>• 1573 ширхэг номыг ангилах, төрөлжүүлэх, бүлэглэх<br>• Барууны шилдэг эрдэм шинжилгээний сэтгүүлийг тогтмол захиалах. /Foreign Affairs гм/ |
| 4 | ХӨТӨЛБӨРИЙН УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ | • Багшийн нөөцийг бүрдүүлэхдээ аль болох олон сургууль, олон соёлын суурийг харж бүрдүүлэх |
| 5 | Оюутанд чиглэсэн үйл ажиллагаа | • Танилцах болон үйлдвэрлэлийн дадлагыг удирдамжыг олон улсын стандартад ойртуулан шинэчлэн боловсруулах / үүнд гадны их дээд сургуулийн дадлагын удирдамжыг судлах/<br>• Гадаад хэл дээр ялангуяа Англи хэл дээр зохиогддог тэмцээн уралдааны тоог нэмэгдүүлэх<br>• Гадаад оюутан элсэх элсэлтийн журмыг боловсруулан нээлттэй болгох |
| 6 | Багшийн үйл ажиллагаа | • Багш нарын хэлний мэдлэг ялангуяа Англи хэлний мэдлэгийг сайжруулахад сургалт зохион байгуулах<br>• Гадны болон дотоодын төсөл, хөтөлбөрт багш нарыг хамруулах<br>• Эрдэм шинжилгээний ажлын явцыг хурдасгах сүүлийн үеийн заах арга зүй, дэвшилтэт онол арга зүйн судалгааг хийх |
| 7 | ЧАНАРЫН ҮНЭЛГЭЭ, БАТАЛГААЖИЛТ | •Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалтын удирдлага Хөтөлбөрийн чанарыг сайжруулах зорилгоор |
| | **Шалгуур** | **Шаардлага** |

| ... | | |
|---|---|---|

Баримт материал, нотлох баримт, уулзалт ярилцлага дээр үндэслэн шинжээчийн баг Их засаг Их сургуулийн Чингис СООСЭ сургуулийн “Олон улсын харилцаа” хөтөлбөрийг БМИҮЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн ерөнхий шалгуур шаардлагад нийцэж байгаа тул “ШАЛГУУРЫГ ...Бүрэн хангасан ..” гэж дүгнэж байна.

Шинжээчийн багийн дүгнэлтийг Нийгмийн шинжлэх ухаан, мэдээлэл, сэтгүүл зүйн чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

Шинжээчийн багийн ахлагчийн нэр, гарын үсэг Ж.Баттогтох

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг С.Сэрчмаа

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг И. Энхболд

**V. Уулзалт ярилцлагад оролцогчдын бүртгэл**

I. Багш нартай хийх уулзалт

| № | Нэр | Албан тушаал | Зэрэг цол | Ажилласан жил | Заадаг хичээл |
|---|---|---|---|---|---|
| 1 | Б. Доржханд | Тэнхимийн эрхлэгч | Ph.D дэд профессор | 15 | • Олон улсын харилцааны онол<br>• Дипломат баримт бичиг боловсруулалт |
| 2 | Д. Чинбаяр | ахлах багш | Магистр | 26/2 | • Бүс нутаг судлалын үндэс<br>• БНХАУ-ын гадаад бодлого |
| 3 | Б. Оюунэрдэнэ | Багш | Магистр | 5 | • Хурлын дипломат ажиллагаа<br>• Япон улсын түүх гадаад бодлого |
| 4 | Х. Нурсауле | Ахлах багш | Магистр | 12 | • Дипломат орчуулга<br>• Англи хэл |

II. Оюутан, суралцагчидтай хийх уулзалт

| № | Оюутны нэрс | Курс | Сонгосон байдал |
|---|---|---|---|
| 1 | Дашдулам | 3 | |
| 2 | Сүлдэрдэнэ | 2 | |

| | | | |
|---|---|---|---|
| 3 | Мөнхзул | 2 | нэгдсэн байдлаар уулзалт зохион байгуулсан |
| 4 | Дөлгөөн | 3 | |
| 5 | Бүүвэйбаатар | 2 | |
| 6 | Тэлмэн | 2 | |
| 7 | Дэнсмаа | 3 | |

II. Ажил олгогчидтой хийх уулзалт

| № | Овог нэрс | Ажлын газар | Албан тушаал | Утас |
|---|---|---|---|---|
| 1 | Д.Булгансайхан | Дацэ-Зобу ХХК | Гадаад харилцаа эрхэлсэн захирал | 99041455 |
| 2 | Б.Нансалмаа | Гүнгийн шивэрт Аудит ХХК | Гадаад худалдаа эрхэлсэн захирал | 99194377 |
| 3 | Ж. Цэрэнмядаг | Төрийн банк | 19-р салбарын захирал | 99997445 |
| 4 | С.Золзаяа | Эпирок Монголиа ХХК | Хүний нөөцийн ахлах бизнес түнш | 99030186 |
| 5 | М.Ариунболд | Мастихин ХХК | захирал | 88096009 |
| 6 | Н.Ган-Эрдэнэ | Улаанбаатар смарт карт | Мэдээлэл технологийн газрын дарга | 80001758 |
| 7 | Д.Алтанхуяг | СХД-ийн захиалагчийн алба | Нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын захирал | 99111986 |
| 8 | С.Шинэтөр | E -mart | хүний нөөцийн менежер | 90001240 |
| 9 | Гомбодорж | Таван богд групп | Монгол грилл менежер | 90114553 |
| 10 | Өнөрцэцэг | Төрийн цахим үйлчилгээний зохицуулалт | гарын дарга | 88052123 |
| 11 | Ч.Сайнбат | Шинэ хорум хотын бүтээн байгуулалтын асуудаал хариуцсан захиргааны | Захиргаа санхүүгийн хэлтсийн дарга | 88083302 |
| 12 | А.Ням-Очир | “Хэв хашмал чөлөөт бүс” ХХК | Хүний нөөцийн хэлтсийн дарга | 88071838 |
| 13 | Т. Маргад-Эрдэнэ | Хөвсгөл аймгийн ЗДТГ-ын | Захиргаа удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн | 88007325 |
| 14 | Б.Сүгэр | БУБУС тур | | 88064197 |
| 15 | Н.БУлганаа | Монтравел компаны | менежер | 99908509 |

III. Төгсөгчидтэй хийх уулзалт

| № | Овог нэрс | Төгссөн он | Ажлын газар | Албан тушаал | Утас |
|---|---|---|---|---|---|
| 1 | Г.Жаргал | 2011 | Япон улс Чиба хот Нарита нисэх онгоцны буудал | Зорчигчийн тээврийн үйлчилгээ | 070-2636-27-36 |
| 2 | Г.Пэрэнлэй | 2019 | Япон улс Окояама муж Юкай ресорт | Зочид буудлын үйлчилгээний ажилтан | 8180-2780-7706 |
| 3 | Б.Мөнгөн-Эрдэнэ | 2018 | Тэнгэр даатгал | Нөхөн төлбөрийн мэргэжилтэн | 89987887 |
| 4 | М.Энхбат | 2019 | Солонгос улс Инчон хот Инха их сургууль | Докторт сурч байгаа | 010-6825-8486 |
| 5 | Ч.Гомбодорж | 2021 | Таван богд грүпп | Мэдээлэл тоног төхөөрөмж хариуцсан инженер | 90114553 |
| 6 | Х.Баярмаа | 2008 | Монгол соробан сургалтын төв | Ахлах багш | 96679777 |
| 7 | Э.Чинхүсэл | 2022 | Nano tech store | Худалдааны зөвлөх | 94458482 |
| 8 | Б.Үржинханд | 2012 | УИХ-ын тамгын газар | УИХ-ын гишүүний шадар туслах | 88099373 |
| 9 | А.Баттулга | 2008 | Япон улс гифү муж юкай ресорт | Үндсэн ажилтан | 8170-3875-5263 |
| 10 | Б.Батхишиг | 2014 | Нийслэлийн МАН-ын хороо | Улс төрийн бодлогын хэлтсийн ахлах ажилтан | 95956952 |
| 11 | Н.Эржена | 2019 | Орос 3-р сургууль | Нэмэлт боловсролын багш | 95782059 |
| 12 | Н.Ганчимэг | 2020 | Төрийн Цахим Үйлчилгээний Зохицуулах Газар | Мэргэжилтэн | 86020252 |
| 13 | Ган-Эрдэнэ | 2019 | АНУ Чикаго хот | Магистрт сурах гэж байгаа | |
| 14 | Х.Уламбаяр | 2008 | 25 суваг ТВ | Сэтгүүлч | |
| 15 | Г.Төгөлдөр | 2019 | Япон улс Окояама муж Юкай ресорт | Зочлох үйлчилгээ хариуцсан ажилтан | |
| 16 | Ц.Энхцогт | 2009 | БЦО трайнинг | Гүйцэтгэх захирал | 99049954 |
| 17 | Wei Mengyung | 2015 | БНХАУ-ын хөрөнгө оруулалттай Хн Шин Вэй Иэ ХХК | Гадаад харилцааны албаны дарга | 86771111 |
| 18 | Э.Оюун-Эрдэнэ | 2015 | Санти ХХК | Хятад хэлний орчуулагч | 88054525 |
| 19 | Л.Болортуяа | 2009 | Их Засаг МСҮТ | Сургалтын албан дарга | 88115983 |

| 20 | У.Батдорж | 2019 | Япон улс Окояама муж Юкай ресорт | Зочид буудлын үйлчилгээний ажилтан | 070-2636-27-36 |
|---|---|---|---|---|---|

**YI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр**

Мэргэжлийн зөвлөлийн хуралдаан (огноо) ..............
Мэргэжлийн зөвлөлийн хэлэлцүүлгийн дүгнэлт...
Зөвлөмж….
Шаардлага...

| Магадлан итгэмжлэх эсэх | Магадлан итгэмжлэл олгох хугацаа |
|---|---|
| | |

**YII. Дээд боловсролын магадлан итгэмжлэх комиссын шийдвэр**

Магадлан итгэмжлэх комиссын хуралдаан (огноо)..............
Магадлан итгэмжлэх комиссын хэлэлцүүлгийн дүгнэлт…
Зөвлөмж….
Шаардлага...

| Магадлан итгэмжлэх эсэх | Магадлан итгэмжлэл олгох хугацаа |
|---|---|
| | |